ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.09.08 № 1199

танай ____________-ны №____________-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Монгол Ардын Хувьсгалт намын Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-

2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол Ардын Хувьсгалт намын мөрийн хөтөлбөр /.7. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Налайх дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 7.. хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ**
**АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ**

Налайх дүүргийн Монгол Ардын Хувьсгалт Намын
Удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
хуралдаанаар хэлэлцэж батлав.

# НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## "НАЛАЙХЫН ИРГЭН-НАЛАЙХЫН БАЯЛАГ" ХӨТӨЛБӨР

**Зорилго:**

**"НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ"** нь Налайхын дүүргийнхээ ард иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, Монгол Улсын язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, ард иргэдийнхээ аз жаргалтай амьдрах хүсэл тэмүүллийг хөхиүлэн дэмжих нь туйлын чухал зорилго мөн хэмээн үзэж байна.

**"НАЛАЙХЫН ИРГЭН-НАЛАЙХЫН БАЯЛАГ"** Мөрийн хөтөлбөрийг иргэдийнхээ санал хүсэлт, дүүргийн 5000 гаруй иргэдийн санал санаачилгад тулгуурлан боловсруулснаа өргөн дэвшүүлж байна.

Эрхэм хүндэт Налайхчууд, Та нийт иргэд, нийгмийн бүх давхаргын төлөөлөгчдийн санал, хүсэл, мөрөөдлийг шингээсэн энэхүү **"НАЛАЙХЫН ИРГЭН-НАЛАЙХЫН БАЯЛАГ" Мөрийн хөтөлбөрийг** өргөн барьж байгааг хүлээн авна уу.

## "НАЛАЙХЫН ИРГЭН-НАЛАЙХЫН БАЯЛАГ" хөтөлбөр:

Орон нутгийнхаа эзэн, эрүүл саруул, өргүй, өндөр боловсролтой **НАЛАЙХЧУУД–НАЛАЙХЫН суурь баялаг;**

Ажилтай, орлоготой, орон сууцтай **НАЛАЙХЧУУД – НАЛАЙХЫН тулгуур баялаг;**

Хүнээ хамгаалдаг, авилгаас ангид **ЗАСАГ, ЗАХИРГАА – НАЛАЙХЫН түшиг баялаг мөн.**

Энэхүү гурван баялгийн амин холбоог сэргээн орон нутгаа өнөөгийн гүнзгий хямралаас гаргах хөгжил цэцэглэлтийн бодлогыг тодорхойлж байна.

### Нэг. НАЛАЙХЧУУД– НАЛАЙХЫН суурь баялаг;

Налайхчууд Налайхын суурь баялаг мөн. Налайхчууд төр засгийн хамгаалалтад байж, эх орондоо ажил хөдөлмөр эрхлэх, амьдралд нь хүрэлцэхүйц цалин орлоготой байх бүрэн эрхтэй. Амьдралын нугачаанд ядарч зүдэрсэн ард иргэдээ хүний дайтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх нь орон нутгийн засаг захиргааны үндсэн үүрэг мөн.

1117145633
УХА0612 907727

**1.1 Цалин, орлого:**

- Хүний цалин, орлогыг үе шаттайгаар тууштай нэмэгдүүлэх бодлого баримтлан хэрэгжүүлэхдээ өнөөдөр, маргаашдаа санаа зовохгүй байх, амьдралд хүрэлцэхүйц байх шалгуурыг баримтална.

- Орон нутгийн хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшний үзүүлэлтийг инфляцын түвшин, хөдөлмөрийн бүтээмж, эдийн засгийн өсөлт зэрэгтэй уялдуулан өнөөдөртөө санаа зоволгүй амьдрах хэмжээнд үе шаттайгаар хүргэх “баталгаатай орлого” олгох замаар ядуурлын түвшинг мэдэгдэхүйц бууруулна.

**1.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан:**

- Ерөнхий боловсролын сургуулиудад шинжлэх ухааны мэдлэг олгохын зэрэгцээ монгол соёл уламжлал, ёс заншлаа дээдэлсэн, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэж, амьдралдаа эзэн болж явах чадвар суулгахад түлхүү анхаарна.
- Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хүртээмж, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ. Хүүхдийн сурах чадварт тохирсон орчин нөхцөлийг бүрдүүлж хоёр ээлжийг халах талаар бодлого боловсруулах зөвлөх үйлчилгээ хийлгэнэ.
- Гадаад хэлийг хүүхэд бүр эзэмших тэгш боломжийг хангах боломжийг судалж, дугуйлангийн тоог нэмэгдүүлнэ.
- Дүүрэгт үйл явуулж буй зарим Ерөнхий боловсролын сургуулийг шинжлэх ухаан, технологийн чиглэлээр төрөлжүүлэн гүнзгийрүүлсэн сургалттай болгон өөрчлөн зохион байгуулж, амьдралын түвшингээс үл хамаарч хүүхдүүдийг суралцах боломжоор тэгш хангана.
- Ахлах ангийн сурагчдад дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудын тэтгэлэгт тэнцэх, хамрагдах хөтөлбөр боловсруулна.
- Сурагч бүрийг нийгэмд тустай сайн дурын ажил хийдэг соёлыг нэвтрүүлж, энэ тухай харьяа боловсролын байгууллагаас албан ёсны тодорхойлолт гаргаж өгдөг зохицуулалт хийнэ.
- Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, коллеж, их, дээд сургуулиудын үндсэн хөтөлбөрүүдийг онлайн хувилбартай болгож, онлайн сургалт зохион байгуулдаг болно.
- Шинжлэх ухаан, инновацийн хөгжилд орон нутгийн төсвийн 3 хувиас доошгүй хувийг зэрцуулах бодлого боловсруулна.
- Налайхчуудынхаа соёл, өв уламжлал, ёс заншил, тэмүүллийг бусад дүүрэг, хороодод бүхий л хэлбэрээр сурталчилна.

**1.3 Эрүүл мэнд:**

- Жил бүр 40-өөс дээш насны иргэдийн хавдрын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүйгээр заавал хамрагддаг болох зохицуулалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулна.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор нийтийн биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал болгохыг дэмжинэ.
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд бүх нийтээр эрүүл, цэвэр, аюулгүй орчинд аж төрөх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн эрүүл мэндийн боловсролын дэмжиж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвүүдийг дүүрэгт байгуулна.
- Дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлж, эрт үед зөв онош тогтоосноор зөв эмчилгээ, үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулна.
- Алслагдсан хороодод эмийн сан байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.

**1.4 Бизнес эрхлэгчид:**

- Шинээр бизнес эрхлэх хүсэлтэй иргэдэд гарааны бизнесийн хүүгүй зээл, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох санхүү, зээлийн тогтолцоог орон нутагт бий болгох бодлогын судалгаа хийж, хэрэгжүүлнэ.

1117145633
УХА0612 9077278

### 1.5 Эмэгтэйчүүд:

- 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд өөрсдийнх нь хүсэлтээр аль нэг нь гэртээ хүүхдээ асрах тохиолдолд өнөөдөртөө санаа зоволгүй амьдрах хэмжээнд хүрэхүйц "баталгаатай орлого"-ыг олгодог тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.
- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг авч байгаа цалинг нь бууруулалгүйгээр богиносгосон цагаар ажиллуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.

### 1.6 Залуучууд, спорт:

- Гарааны бизнесийг дэмжих "Старт ап" хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан "Дундын оффис" байгуулан ажиллуулах буюу тодорхой хугацаанд түрээс төлөлгүйгээр өөрийн төсөл, хөтөлбөр, шинэ санааг боловсруулах ажил хийх нөхцөлийг орон нутагтаа бүрдүүлнэ.
- Залуучуудын бизнес санаачлагыг дэмжих "Старт ап" сан байгуулж ажиллуулна. Жил бүр наад зах нь 100 гарааны бизнесийг дэмжих бодлого боловсруулна.

### 1.7 Ахмадууд:

- Орон нутгийн засаг захиргааны байгууллага бүр ахмадуудыг орон тооны бус сайн дурын зөвлөхөөр авч ажиллуулдаг болно.
- Дүүрэг, хороодод ахмадуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх төв байгуулж, үйл ажиллагааг нь дэмжиж ажиллана.
- Ахмад настангуудынхаа гаргаж ирсэн шинэ санаачилга, тэргүүн туршлагыг орон нутагт түгээх, тэднийг алдаршуулах ажлыг өргөн хэмжээнд зохион байгуулна.

### 1.8 Хүүхдүүд:

- Эрүүл мэндийн олон улсын стандартад нийцсэн эх, нялхсын "Эх нялхас" орон нутгийн дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Малчин болон мал бүхий өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг орон нутагт явуулын хэлбэрээр зохион байгуулна.
- Хүүхдийн оролцооны байгууллагуудаас гаргасан санал санаачилга, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг орон нутагтаа дэмжиж ажиллана.
- Хороонд хүүхдийн оролцооны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бүх түвшинд онцгойлон анхаарч, тэдний гаргасан санал, санаачлагыг дэмжиж, хэрэгжүүлэх бодлого баримтлана.
- Хүүхэд залуучуудын амралт чөлөөт цагийн талбайг сэргээн засварлах, арчлалт хамгаалалтад онцгойлон анхаарч ээнжүүлнэ.
- Хороонд номын сан байгуулж, үйл ажиллагааг нь дэмжиж, орчин үеийн номын сангийн стандартыг нэвтрүүлнэ.
- Хүүхдүүд, залуучуудын дунд дүүрэг, хороонд тулгамдаж буй асуудлаар онол практикийн бага хурал зохион байгуулж, шинэ санаа, шинэлэг бүтээлийг хөгжлийн төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх ажлыг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулах замаар цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана.

### 1.9 Оюутан, сурагчид:

- Дэлхийн шилдэг их, дээд сургуульд магистр, докторын сургалтад хамрагдах эрх авсан оюутнуудын сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг гадаад улсуудын дэмжлэг, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар өргөжүүлэн хөгжүүлэх бодлого боловсруулна.
- "5+5" хөтөлбөр буюу 5 сар суралцах, 5 сар цалинтай ажил хийх хөтөлбөрийг аж ахуйн нэгж байгууллагуудын дэмжлэг, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

1117145644
УХА0612 9077278

- Орон нутгийн оюутан залуучуудыг өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн амьдралд идэвхитэй оролцох боломжийг бүрдүүлж, номын сан, чөлөөт цагаа өнгөрөөх төвүүдийг ажиллуулна.
- Налайх хотын залуучуудын оролцооны байгууллагуудаас гаргасан санал санаачлагыг ажил хэрэг болгож, "Залуучуудын төлөө-Налайх" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар амжилт гаргасан хүүхэд, өсвөр үеийнхний бүтээл туурвилыг нь дэмжиж, олон нийтэд сурталчилна.
- Хорооны иргэдийн урлаг, уран сайхны наадмыг уламжлал болгон зохион байгуулж, дүүргийн бусад хороодод зохион байгуулна.

### 1.10 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд.

- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр орон нутгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх сувилал, эмнэлэг шинээр байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг зүй зохистой амьдрах, нийгмийн харилцаанд оролцоход төр засгаас онцгойлон дэмжлэг үзүүлэх бодлогын судалгаанд тусган, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.
- Жижиг, дунд бизнес эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өрх гэрийг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гэр бүлийн аж ахуйн нэгж оролцсон бүлэг, нөхөрлөлийг дэмжиж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагчид өнөөдөртөө санаа зоволтгүйгээр амьдрах хэмжээнд хүрэх "баталгаатай орлого"-ыг буюу тэтгэмжийг олгох талаар бодлогын судалгааг хийж дуусгана.
- Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчныг бүрдүүлэх шаардлагыг журамлаж, биелэлтийг хангуулж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрх, мөн улс төр, нийгэм, эдийн засгийн аль ч салбарт бусдын адил ажиллах боломжийг дэмжиж ажиллана.
- Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлж буй хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг оновчтой зөв зохион байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан тохируулгатай ажлын байр бий болгох, хөдөлмөрийн хуулийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхчүүдийг хамруулах хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллана.

## Хоёр. Ажилтай, орлоготой, орон сууцтай өрх гэр

Налайхчуудын тулгуур баялаг нь өрх гэр бүл мөн тул төр засгаас гэр бүлийг дэмжих бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

### 2.1 Орон сууцжуулах:

- Орон сууц шаардлагатай өрх бүрийг урт хугацаанд бага багаар эргэн төлөгдөх нөхцөлөөр орон сууцжуулах "Өрх бүрт орон сууц" Үндэсний хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж ажиллана.

### 2.2 Малчин өрхүүд:

- "Малчин өрх-үйлдвэрлэгч" хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхүүд хамтарч сүү цагаан идээ, арьс шир, ноос ноолуур боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн, малын тэжээл үйлдвэрлэх зэргээр жижиг, дунд бизнес эрхлэхэд нь төр засгаас бодлогоор дэмжинэ.
- Малчин өрхийн бага насны хүүхдэд бага ангийн боловсрол олгохдоо "Багш ээж" хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

УХА0612 9077278

- Бэлчээрийн талбайг сэргээх, нэмэгдүүлэх, өвс ургамлын гарцыг сайжруулах зорилгоор усжуулах, худаг ус гаргах, булаг шанд хамгаалах, сэргээх, цөөрөм байгуулах санаачлагыг дэмжинэ.
- "Мал эрүүлжүүлэх" хөтөлбөр хэрэгжүүлэх замаар мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухайлсан байгууллагыг өргөжүүлж, чадавхыг нь нэмэгдүүлнэ.
- Орон нутагт орчин үеийн шаардлагад нийцсэн мах боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.
- Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, нарийн ногооны тариаланг хөгжүүлнэ.

**Гурав.** Орон нутгийн **ЗАСАГ, ЗАХИРГАА – НАЛАЙХЫН түшиг баялаг мөн.**

Та бид хамтдаа ОРОН НУТГИЙНХАА ЗАСАГ ЗАХИРГААГ эмхлэн байгуулна. Төр засгийн бодлого шийдвэрийг харьяа орон нутагтаа хэрэгжүүлэх, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг чадавхжуулна.

**3.1. Төрийн алба**

- Мэдлэг боловсрол, мэргэшил, туршлага, ур чадвар, оюуны чадавхтай иргэдийг нам үл харгалзан төрийн албанд тогтвортой ажиллуулна.
- Мэргэжил, боловсролоороо төрийн албанд тэнцэн тогтвор суурьшилтай ажилласан, мэргэшсэн албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээс шалтгаалан хууль бусаар олноор нь халдаг бусармаг явдлыг орон нутагтаа таслан зогсооно.

**3.2. Авлигаас ангид орон нутгийн засаг, захиргаа:**

- Хорооны иргэний танхимыг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- Авлигын эсрэг дүүргийн сайн дурын иргэдийн бүлгийг байгуулж, хамтарч ажиллана.
- Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг ил тод болгон, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ хорооны тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг байх нөхцөлийг журамлох ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- Хорооны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулан олон нийтэд ил тод мэдээллэн, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг болно.
- Төрийн байгууллага, албан тушаалтанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, ажилтан албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг өргөн хэмжээнд зохион байгуулна.

**3.3. Аж үйлдвэр:**

- "Туул", "Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн", "Бүс нуур амралт чөлөөт цагийн талбай" зэрэг газруудын ашиглалтыг сайжруулж, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд аялал жуулчлалын зориулалтаар хамтран ажиллах гэрээ байгуулж, дүүргийн төсвийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхэд санаачилга гаргаж ажиллана.
- Иргэд оршин суугчдын амьдрах эрүүл, тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор "Орон нутгийн хөгжлийг дэмжих" сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хорооны хөгжлийн чиг хандлагад тулгуурлан иргэд, олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж, зарцуулах боломжийг улам боловсронгуй болгоно.

111/145633
УХА0612 9077278

- Барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материалын үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулах бодлогыг дэмжиж, ажил хэрэг болгохын төлөө анхаарч ажиллана.
- Барилгын материалын бөөний худалдаа, логистикийн төв, Налайхын барилгын материал үйлдвэр технологийн парк, сайжруулсан түлшний үйлдвэр, бусад томоохон стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд бүх түвшинд санал, санаачилга гаргаж, идэвхитэй санаачилгатай ажиллана.

**3.4. Хөнгөн ба хүнсний үйлдвэр:**

- Орон нутагтаа хүнсний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран дэмжиж ажиллана.
- Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэд, бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг орон нутгийн зүгээс дэмжиж ажиллана.

**3.5. Жижиг, дунд үйлдвэрлэл:**

- Мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилго нь химийн бордоогүй органик, хүний биед нэн тустай, зах зээлд өндөр үнэ хүрэх бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд нийлүүлэхэд оршино.

- Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, органик мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр орон нутгийнхаа хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар төв суурин газарт борлуулах орчин нөхцөлийг бий болгоно.
- Орон нутагт мал аж ахуй, хөдөө аж ахуйн гол гол бүтээгдэхүүнийг хийж байгаа иргэдээсээ орон нутгийнхаа худалдан авах, малчид, тариаланчдыг мал аж ахуй, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн үнийн огцом хэлбэлзлийн цохилтоос хамгаална.

**3.6. Экологийн тэнцвэртэй байдал:**

- Орон нутгаа унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, түүний баялгийг хойч үедээ өвлүүлж ирсэн үндэсний уламжлалаа шинэ цагийн "Ногоон хөгжлийн үзэл баримтлал"-тай уялдуулан баримтална.
- Хүрээлэн буй орчинд хор хөнөөлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулахыг хязгаарлах, хориглох бодлого баримтлан хэрэгжүүлнэ. Хог боловсруулах үйлдвэрүүдийг шинээр барьж байгуулна.
- Мод тариалж ногоон зурвас байгуулах "Ногоон хэрэм" хөтөлбөрийг үргэлжлүүлэн өргөжүүлж, ойн сан дундын эзэмшлийн зарчмаар нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ой хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах зорилгоор "Ой" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Гол мөрний ай савыг ойжуулах ажлыг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ. Газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан ойн мэдээллийн сан байгуулна.
- Усны эх бүрэлдэх сав газар, усны ундарга, нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, сан бүрдүүлэх зэрэг усыг зүй зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах "Ус" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн тахилгатай уул, гол мөрөн, нуурын эко системд хор хохирол учруулахгүйн тулд тэдгээрийн ойролцоо ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахыг дүүргийн зүгээс хориглоно.

- Туул голын байгалийн тогтолцоог сэргээн хамгаалж, Тэрэлж голыг түшиглэн усан сан байгуулах замаар нийслэлийн ундны усны хангамжид гадаргын усыг ашиглах боломжийг нэмэгдүүлнэ.
- Налайх дүүргийн эко системийн хямралыг давах буюу хотын агаар, хөрс, усны бохирдлын явцыг зогсоон сэргээх цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Орон нутагт тохирсон ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээг эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт бий болгож, ногоон хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг улам боловсронгуй болгон, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого явуулна.

**3.7. Дагуул хотыг хөгжүүлэх**

- Монгол Улсын газар зүйн байрлал, байгалийн баялаг, дэд бүтцийн сүлжээг үндэслэн эдийн засгийн бодлогыг хүн ам зүйн бодлоготой уялдуулан улс орны хөгжлийг эрчимжүүлэх "Улсын чанартай дагуу хот" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Налайх дүүргийг дагуул хот болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгож, бүтээн байгуулалтын их ажлын ТЭЗҮ-г боловсруулж, "Төр-хувийн хэвшил"-ийн түншлэлээр эхлүүлэх ажлыг зохион байгуулна.

**Мөрийн хөтөлбөр хэрэгжих баталгаа**

Налайхчууд бид дэлхий дахины хөгжилтэй улс орны нэгэн адил эрчимтэй хөгжих, чинээлэг амьдрах бүрэн бололцоотой гэдгийг Та бид гүнээ ухамсарлаж байгаа юм. Та бид юуны түрүүн орон нутгийнхаа засаг, захиргааг ард иргэддээ эгүүлэн өгч, хариуцлагатай орон нутгийн удирдлагыг ард иргэдийнхээ хүсэл зоригоор эмхлэн байгуулах нь энэхүү мөрийн хөтөлбөр хэрэгжих хамгийн том баталгаа – Налайхчуудын хөгжлийн дотоод хүчин зүйл мөн.

Налайх дүүргийг хөгжүүлэх хамгийн гол нөөц баялаг бол Налайхчууд бид билээ. Төрийн албанд орон нутгаа хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавьж чаддаг хүмүүсийг тогтвортой ажиллуулна. Та бид Монгол хүний саруул ухаанд итгэх ёстой.

Эрхэм сонгогчид оо!

Зовхи нь єєдєє, зориг нь хурц, ухаан сэргэлэн та бүхэн минь сайхан амьдрах хувьтай хvмvvс.

Нэгэн сайн санаа байвал бусадтай хуваалц,
Нэгэн сайн vйлс бvтээх гэвэл бусдын тєлєє зvтгэ гэдэгсэн.

Тvvхийг бvтээлцэж, бусдыг бишрvvлж ирсэн та бүхэн минь
Сэрэхдээ шувуу шиг сэрдэг
Босохдоо унага шиг босдог хийморьтой, гэр бүлээрээ эрүүл энх, аз жаргалаар дүүрэн байж, энэ сайхан орон нутгийн минь хєгжлийн зам, оршихуйн зай уудам байх болтугай

**Налайх дүүргийн Монгол Ардын Хувьсгалт Нам**

1117145633
УХА0612 9077278

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.08 № 1197

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050", нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Монгол Ардын Хувьсгалт намын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

002020939

Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол Ардын Хувьсгалт намын мөрийн хөтөлбөр / 6 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 6 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

МАХН-ын Нийслэлийн Түмтийн зөвлөлийн
2020 оны 06 дугаар сарын ....-ны өдрийн
хуралдаанаар хэлэлцэж батлав.

# МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## **"Та Бидний ХОТ"**

Зорилго:

Монгол Ардын Хувьсгалт Нам нь Монголын ард түмний эрх ашиг, тэр дундаа Нийслэлийн иргэдийн хүсэл сонирхлыг удирдлага болгож, Монгол Улсын язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, ард түмнийхээ аз жаргалтай амьдрах хүсэл тэмүүллийг хөхиүлэн дэмжих нь туйлын чухал зорилго мөн хэмээн үзэж, түүнд хүрэхийн тулд:

- Нийслэлийн иргэдээ ажлын байраар хангах
- Нийслэлийн хөгжлийг нийтэд тэгш хүртээх
- Өрх бүрт орон сууц хөтөлбөрийг Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах,

зорилт бүхий иргэдийнхээ санал хүсэлд тулгуурлан боловсруулсан **"Та Бидний ХОТ " мөрийн хөтөлбөрөө** танилцуулж байна.

1117145633
УХА0612 9077278

## Та бидний ХОТ

Нийслэлийн иргэн Та, бид хамтран таны санаачилга, бидний зүтгэлээр Нийслэл хотоо хөгжлийн зөв замд нь оруулах гарц бий. Энэ нь хөгжлийн бодлогоо иргэдийнхээ оролцоонд тулгуурладаг, иргэддээ үйлчилдэг, иргэд нь хяналт тавьдаг, орчин цагийн хүн төвтэй шинэ хотын чиг хандлагад нийцүүлэн Нийслэл хотоо хөгжүүлнэ. Дарга нарт зориулсан биш, иргэддээ, хүүхдэд, залууст, эмэгтэйчүүдэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, ахмадуудад, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хүн бүхэнд ээлтэй Улаанбаатар хотыг Та бид хамтран бүтээнэ.

### НЭГ. Таны төлөө Тантай хамт

1. Нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, үндэс угсаа, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй амьдран, сурч боловсорч, аз жаргалаа эрэлхийлэх **тэгш боломж, тэгш хүртээмж** бүхий амьдралын суурь зарчмийг эрхэмлэнэ.

2. Нас насны онцлогт харгалзсан тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэн **иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.** Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, нийгмийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг зогсооно.
3. Залуучуудад зориулсан **гарааны бизнесийг дэмжих "Старт ап" хөтөлбөрийг х**эрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан "Дундын оффис" байгуулан ажиллуулах буюу тодорхой хугацаанд түрээс төлөлгүйгээр өөрийн төсөл, хөтөлбөр, шинэ санааг боловсруулах ажил хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
4. Залуучуудын бизнес санаачлагыг дэмжих **"Старт ап" сан** байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Жил бүр наад зах нь 1000 гарааны бизнесийг дэмжих бодлого боловсруулна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний ар гэр, асран хамгаалагч нарт зориулсан тусгай хөтөлбөрийг санаачилна.
6. **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан тохируулгатай ажлын байр бий болгох**, хөдөлмөрийн хуулийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхчүүдийг хамруулан оруулна.
7. Худалдааны салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд бүх шатны бодитой дэмжлэг үзүүлдэг хот болно.
8. Эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесийг дэмжих зорилготой **"Эмэгтэйчүүдийн хөгжил" сан** байгуулах ажил эхлүүлнэ.

1117145533
УХАӨЕ12 9077278

9. 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд өөрсдийнх нь хүсэлтээр аль нэг нь гэртээ хүүхдээ асрах тохиолдолд амьдралд хүрэхүйц "баталгаатай орлого"-ыг олгодог тогтолцоонд үе шаттайгаар шилжих бодлогыг боловсруулна.
10. Жирэмсэн эмэгтэйчүүд, 3-5 насны хүүхэдтэй ажилтныг авч байгаа цалинг нь бууруулалгүйгээр богиносгосон цагаар ажиллуулдаг тогтолцоог бүрдүүлэх санаачилгыг дэмжинэ.
11. Ахмадуудыг нийслэлийн төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр зохих урамшууллалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг урамшуулах тогтолцоо бүрдүүлэх бодлогыг боловсруулна.
12. **"Та бидний** хүүхэд бүр амьдралын түвшинээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон Их дээд сургуульд суралцах **тэгш боломжийг** бүрдүүлнэ. Улаанбаатар хотын тэргүүний сургуулийн туршлага, арга зүйг бусад бүх сургуульд нэвтрүүлэх зорилгоор багш, удирдах ажилтангуудыг сэлгэн томилох, сайн туршлага нэвтрүүлнэ.
13. 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан **эрт дэмжлэгийн хөтөлбөр** боловсруулж, хэрэгжүүлнэ.
14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвүүдийг дүүрэг бүрт байгуулах ажлыг дэмжинэ.
15. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний зардлын тодорхой хэсгийг хөнгөлөх тогтолцоонд шилжих бодлогын судалгааг хийнэ.
16. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор **"ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ", "ТА БИДНИЙ ХҮНС"** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**ХОЁР. Таны гэр бүлийн төлөө Тантай хамт**

**Монгол Улсын тулгуур баялаг нь монгол өрх мөн тул төр засгаас гэр бүлийг ажлын байртай, орлоготой байх бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.**

1. Нийслэлийн дүүрэг бүрд "Өрх бүрт орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх бодлогын судалгааг хийнэ. Утаагүй, цэвэр, эрүүл Улаанбаатар хот болгоно.
2. Нийслэл хотын гэр хорооллыг орон сууцжуулахдаа **хувийн сууцыг давуу хөгжүүлэх бодлого** баримтална. Өрх бүрт орон сууц хөтөлбөрийн хүрээнд "Хашаандаа сайхан амьдрах" иргэдийн хүсэл санаачилгыг дэмжин, орон сууцны ипотекийн зээл гэх мэт хөтөлбөрийн ижил нөхцлөөр хашаа байшингаа тохижуулах, орчин үеийн дэд бүтцэд холбогдох санхүүжилтийг шийдвэрлэх ажлыг эхлүүлнэ.

1117145033
УХ..612 9077278

3. **Бичил болон өрхийн бизнесийг дэмжих эрх зүйн шинэ орчныг** бий болгоно. Дүүрэг, хороо бүрт төр, иргэн, хувийн хэвшлийн тэнцүү тооны төлөөлөл бүхий **бичил өрхийн бизнесийг дэмжих төвүүдийг** байгуулна.
4. **Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн шинэ тогтолцоог** бүрдүүлж зорилтот бүлгүүдэд зориулсан доорх:
   - "Эмэгтэйчүүдийн хөгжил сан"
   - "Гарааны бизнесийг дэмжих сан"
   - "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан"
   - "Шинжлэх ухаан, инновацийн сан"
   - "Өрхийн бичил бизнесийг дэмжих сан"
   - "Өрх бүрт орон сууц" сан

   зэрэг санхүүгийн байгууллага байгуулах, хөнгөлөлттэй нөхцөлтэй, бага хүүтэй зээл олгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж айл өрх, аж ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгох санаачлагыг дэмжинэ.

## ГУРАВ. Та бидний амьдрах хотын төлөө Тантай хамт

1. Улаанбаатар хотын гол бэрхшээл болох агаар, хөрс, ус, орчны бохирдол, авто замын түгжрэл, газар төлөвлөлт, дэд бүтцийн асуудлын талаар төлөвлөлт хийж, **цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж, эко орчин бүхий Танд, таны гэр бүлд ээлтэй хотод амьдрах таатай орчныг Иргэн тантай хамтран** цогцлуулна.
2. Автозамын түгжрэл түүнээс үүдсэн хүндрэлийг шийдвэрлэхдээ **газар төлөвлөлт, хот зохион байгуулалтын төлөвлөлтийг шинэчлэн олон төрөлт ухаалаг тээврийн үйлчилгээг** нэвтрүүлнэ.
3. Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх, шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудад **хүүхдийн цэцэрлэг, сургуулийг барих, тэдэнд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх** бодлогыг дэмжинэ.
4. Нийслэлийн номын санг шинээр байгуулна.
5. Хүүхэд, залуучуудын хөгжих таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах **Эко парк, лаборатори** байгуулах ажлыг Нийслэлийн төсвийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
6. **"Эрүүл зөв амьдрал", "Та бидний хүнс" хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад** хэрэгжүүлнэ.

7. Нийслэлийн ногоон орчин, гол усны орчмын газарт **иргэдийн оролцоотой хамгаалалт ашиглалтын шинэ бодлого, байгальд ээлтэй хот хөтөлбөр** хэрэгжүүлнэ.
8. Эх барихын болон нярайн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай эм хэрэгслийн санхүүжилтийг төсвөөс бүрэн хариуцдаг болох асуудлыг дэвшүүлэн тавина.
9. Багш нарыг орон сууцжуулах багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор **"Багш" сан** байгуулж, ажиллах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.
10. Нийтийн унаа, нүхэн гарц, зам зэргийг **хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан стандарт**ыг хангахуйц, тэдэнд таатай байхаар өөрчилнө.

1117145633
УХА0612 5077278

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.08 № 1204

танай ____________-ны № ____________-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Монгол Ардын Хувьсгалт намын Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол Ардын Хувьсгалт намын мөрийн хөтөлбөр 13 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

МАХН-ын Сүхбаатар дүүргийн
удирдах зөвлөлийн 2020 оны
06 дугээр сарын 17-ны өдрийн
хуралдаанаар хэлэлцэж батлав.

# ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СҮХБААТАР ДҮҮРГИЙН "ТА БИДНИЙ ДҮҮРЭГ" МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Зорилго

Сүхбаатар дүүргийн МАХН нь иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй хотод амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн бүр эрүүл аюулгүй дүүрэгт амьдрах эрхийг дээдлэж Өрх бүрт орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэн Сүхбаатар дүүрэгт жил бүр иргэдийг орон сууцаар хангах бодлогын судалгаа хийнэ.
- Дүүргийн иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс гаргадаг болох бодлогын судалгаа хийнэ.
- Орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий эмнэлгийг барих байршлыг шийдвэрлэнэ.
